МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ,
ДОТООД ХЭРГИЙН САЙД

Засгийн газрын V байр, Б.Ширэндэвийн гудамж 8/4,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас/Факс: (976-51) 26 75 33,
Цахим шуудан: info@mojha.gov.mn,
Цахим хуудас: www.mojha.gov.mn

2024.01.25 № 1/342

танай 2023.12.26-ны № 03/3421-т

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН САЙД Х.БУЛГАНТУЯА
ТАНАА

"Журам, гэрээний загвар батлах тухай" Хөдөлмөр, нийгмийн хамгаалын сайдын 2023 оны А/200 дугаар тушаалыг захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн сангийн ...6563... дугаарт бүртгэж хүргүүлэв.

Б.ЭНХБАЯР

1?1??0171

Doc.yam a5.2024

Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд 2024 оны 01 сарын 24 ны өдрийн 6563 дугаарт бүртгэв.

# МОНГОЛ УЛСЫН ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙДЫН ТУШААЛ

2023 оны 12 сарын 25 өдөр Дугаар А/200 Улаанбаатар хот

Журам, гэрээний загвар батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5 дахь хэсэг, Нийгмийн даатгалын ерөнхий хууль /шинэчилсэн найруулга/-ийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсэгт заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Нийгмийн даатгалд сайн дураар даатгуулахад баримтлах журмыг нэгдүгээр хавсралтаар, нийгмийн даатгалд сайн дураар даатгуулсан тухай гэрээг хоёрдугаар хавсралтаар, гурав хүртэлх насны хүүхдээ асарч буй эхийн нийгмийн даатгалд сайн дураар даатгуулсан тухай гэрээг гуравдугаар хавсралтаар, малчин, туслах малчны нийгмийн даатгалд сайн дураар даатгуулсан тухай гэрээг дөрөвдүгээр хавсралтаар, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч байгаа ажил хөдөлмөр эрхлээгүй эх /эцэг/-ийн нийгмийн даатгалд сайн дураар даатгуулсан тухай гэрээг тавдугаар хавсралтаар тус тус батлацугай.

2.Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн даатгалын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар (Б.Батжаргал)-т, хэрэгжүүлж ажиллахыг Нийгмийн даатгалын ерөнхий газар (Л.Мөнхзул)-т тус тус үүрэг болгосугай.

САЙД Х.БУЛГАНТУЯА

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ ТЭГҮҮГЭЭ
ХУУЛБАР ҮНЭН
ТӨРИЙН ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ГАЗРЫН ДАРГА
Гарын үсэг
2023 оны 12 сарын 25 өдөр

151230559

D: 2023 on 12 sar tushaal

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн А/200 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

Нийгмийн даатгалд сайн дураар даатгуулахад баримтлах журам

## Нэг. Нийтлэг үндэслэл

1.1.Энэхүү журмын зорилго нь Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэгт заасны дагуу даатгуулагчийн хөдөлмөр эрхлэлтийн мэдээллийг бүртгэх, нийгмийн даатгалд сайн дураар даатгах, гэрээ байгуулах, хугацааг нь сунгах, цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын хэмжээ, гэрээ дуусгавар болгох, цуцлах, хүчингүйд тооцох, талуудын эрх, үүрэг, тайлан гаргах, хяналт тавих, маргаан шийдвэрлэх, хариуцлагатай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

## Хоёр. Сайн дурын даатгалд хамрагдах даатгуулагч

2.1.Нийгмийн даатгалын сайн дурын даатгалд дараах хөдөлмөр эрхлэгч даатгуулагч, иргэн хамрагдана. Үүнд:

2.1.1.нийгмийн даатгалд албан журмаар даатгуулснаас бусад иргэн, хувиараа хөдөлмөр эрхлэгч, хувиараа тээвэр эрхэлдэг жолооч, бичил уурхай эрхлэгч, газар тариалан эрхлэгч (ногоочин), төрөөс олгох урамшуулалд хамрагдсан иргэн, хөдөлмөрийн чадвараа алдсан хүн, оюутан, гэрийн үйлчилгээний болон түүнтэй адилтгах ажилтан, цалингүй нэг ба түүнээс дээш сарын захиргааны чөлөө авсан ажилтан, гадаад улсад ажиллаж, амьдарч байгаа Монгол Улсын иргэн, тус улсад амьдарч байгаа гадаадын иргэн, харьяалалгүй хүн;

2.1.2.гурав хүртэлх насны хүүхдээ асарч буй эх;

2.1.3.малчин, туслах малчин;

2.1.4.эмнэлгийн хяналтад байдаг, байнгын асаргаа шаардлагатай 18 хүртэлх насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч байгаа ажил хөдөлмөр эрхлээгүй эх /эцэг/.

## Гурав. Сайн дураар даатгуулсан тухай гэрээ байгуулахад бүрдүүлэх баримт бичиг

3.1.Даатгуулагч сайн дурын даатгалд даатгуулахдаа дараах баримт бичгийг цаасан эсхүл цахим хэлбэрээр бүрдүүлнэ. Үүнд:

3.1.1.иргэний үнэмлэх;

3.1.2.энэ журмын 2.1.2-т заасан даатгуулагч нь хүүхдийн төрсний гэрчилгээ;

3.1.3.энэ журмын 2.1.3-т заасан даатгуулагч нь гэрээ байгуулахын өмнөх жилийн мал, тэжээвэр амьтад, малын хашаа, худгийн тооллогын маягт (цаашид "мал тооллогын "А" данс" гэх);

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ ТЭАГУУГ
ХУУЛБАР ҮНЭН
ТӨРИЙН ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ГАЗРЫН ДАРГА
Гарын үсэг:
2023 он 12 сар 25 өдөр

3.1.4.малчин өрхийн гишүүн нь малчин өрхийн бүртгэлд малчнаар бүртгэгдсэн баримт бичиг;

3.1.5.туслах малчин нь малчинтай байгуулсан хөдөлмөрийн гэрээ;

3.1.6.энэ журмын 2.1.4-т заасан даатгуулагч нь хүүхдийн төрсний гэрчилгээ, байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тодорхойлолт.

3.2.Сайн дураар даатгуулагчийн баримт бичгийн мэдээллийг Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн 18 дугаар зүйлийн 18.3-т заасны дагуу төрийн байгууллагын мэдээллийн нэгдсэн сангаас цахимаар авч, ашиглаж болно.

## Дөрөв. Сайн дураар даатгуулсан тухай гэрээ байгуулах, гэрээний хугацаа, шилжилт хөдөлгөөн хийх

4.1.Энэ журмын 2.1-д заасан даатгуулагч нь нийгмийн даатгалд сайн дураар даатгуулах тухай хүсэлтээ аймаг, дүүргийн нийгмийн даатгалын байгууллага (байцаагч)-д өөрийн биеэр, эсхүл цахимаар гаргаж, эхний сарын шимтгэлээ төлсөн тохиолдолд уг хүсэлтийг нь үндэслэн, Нийгмийн даатгалын байгууллага (байцаагч) тухайн даатгуулагчтай “Нийгмийн даатгалд сайн дураар даатгуулсан тухай гэрээ” (цаашид “гэрээ” гэх)-г байгуулна.

4.2.Гэрээнд тухайн гэрээний үргэлжлэх хугацаа, даатгуулагчийн шимтгэл төлөх сарын цалин хөлс, түүнтэй адилтгах орлого (цаашид “цалин хөлс” гэх)-ын хэмжээ, сард төлөх шимтгэлийн хэмжээг тодорхой тусгана.

4.3.Даатгуулагч гэрээ байгуулах хүсэлтийн дагуу шимтгэлээ төлсөн сараас эхлэн уг гэрээг хэрэгжиж эхэлсэнд тооцно.

4.4.Нийгмийн даатгалын байгууллага (байцаагч) нь батлагдсан маягтын дагуу даатгуулагчтай байгуулсан гэрээг 2 хувь үйлдэж, нийгмийн даатгалын байцаагч, даатгуулагч тус тус гарын үсэг зурснаар уг гэрээ баталгаажна.

4.5.Даатгуулагч цахимаар гэрээ байгуулж буй тохиолдолд гэрээний нөхцөлтэйгөө танилцаж, “гэрээний нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна” сонголтыг сонгосноор байцаагч болон даатгуулагчийг уг гэрээнд гарын үсэг зурж, баталгаажуулснаар тооцно.

4.6.Даатгуулагч малчин, туслах малчин нь цахимаар 12 сар хүртэл хугацаагаар гэрээ байгуулах хүсэлт гаргасан тохиолдолд уг даатгуулагчийн цахимаар хавсаргасан баримт бичгийг байцаагч хянан шалгаснаар гэрээ баталгаажна.

4.7.Малчин болон малчин өрхийн мал маллаж буй гишүүнийг мал тооллогын “А” дансанд малчнаар бүртгэгдсэн нэр, регистр (иргэний бүртгэлийн дугаар), малчинтай ямар хамааралтайг нотлох баримт бичиг, туслах малчин, малчин

хооронд байгуулсан хөдөлмөрийн гэрээ болон малчны мал тооллогын “А” дансны баримтыг байцаагч хянан, шалгаснаар гэрээ баталгаажна. Малчин гэдгийг нотлох баримт бичиг бүрдээгүй байхад шимтгэл төлсөн хугацааг тухайн даатгуулагчийг малчнаар даатгуулсан хугацаанд тооцохгүй.

4.8.Сайн дурын даатгалын гэрээний хугацаа 12 сар байна. Тусгайлсан нөхцөлөөр байгуулах гэрээг доор дурдсан хугацаагаар байгуулж болно:

4.8.1.Энэ журмын 2.1.2-т заасан даатгуулагч эхийн гэрээг хүүхдийг нь 3 нас хүртэл хугацаагаар байгуулна. Харин даатгуулагч эх уг гэрээний хугацаанд дахин хүүхэд төрүүлбэл шинээр төрсөн хүүхдийн мэдээлэлд үндэслэн гэрээг шинэчлэн байгуулна. Энэ тохиолдолд өмнөх гэрээгээр тохирсон шимтгэлийг бүрэн төлсний дараа гэрээг шинээр байгуулна.

4.8.2.Энэ журмын 2.1.3-т заасан даатгуулагчийн төлөх даатгалын шимтгэлийг улсын төсвөөс хариуцан төлөх хугацаа 5 хүртэл жил байна.

4.8.3.Энэ журмын 2.1.4-т заасан даатгуулагчийн гэрээг байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тодорхойлолтод заасан хугацаагаар байгуулна.

4.9.Журмын 2.1.1-д заасан даатгуулагч гэрээний нөхцөлөө энэ журмын 2.1.2, 2.1.3, 2.1.4-т заасан нөхцөлөөр өөрчлөх хүсэлт гаргасан тохиолдолд гэрээг шинээр байгуулна. Энэ тохиолдолд өмнөх гэрээгээр тохирсон шимтгэлийг бүрэн төлсөн байна.

4.10.Даатгуулагч өмнө байгуулсан гэрээний хугацаа дууссаны дараагийн сард багтаан шимтгэл төлсөн тохиолдолд гэрээний хугацааг өмнөх гэрээний нөхцөлөөр үргэлжлүүлэн сунгасанд тооцно. Даатгуулагч өмнө нь байгуулсан гэрээний нөхцөлөө өөрчлөх тохиолдолд хүсэлтээ нийгмийн даатгалын байгууллагад гаргаж холбогдох өөрчлөлтийг тусган гэрээний хугацааг сунгана.

4.11.Даатгуулагч гэрээний хугацаагаа сунгах хүсэлт гаргасан боловч өмнөх гэрээ дууссанаас хойш 1 ба түүнээс дээш сарын дараа шимтгэл төлсөн бол шимтгэл төлсөн сараас нь эхлэн гэрээг шинээр байгуулсанд тооцно.

4.12.Өмнө нь дуусгавар болсон гэрээний хугацаанд шимтгэлээ бүрэн төлөөгүй даатгуулагчийн тухайн төлөгдөөгүй хугацааны шимтгэлийг нөхөн төлүүлэхгүй.

4.13.Тухайн жилд гэрээний маягт шинэчлэн батлагдсан тохиолдолд өмнө нь байгуулсан гэрээний хугацаанд гэрээг хуучин маягтаар нь үргэлжлүүлнэ. Харин гэрээний хугацааг сунгах эсхүл гэрээний хугацаа дууссан бол шинэ маягтын дагуу даатгуулагчтай гэрээг шинээр байгуулна.

4.14.Гэрээний хугацаанд нийгмийн даатгалын байгууллага хооронд шилжих хүсэлт гаргасан даатгуулагчийн шимтгэл төлөлтийн тооцоог бүрэн хийснээр уг хүсэлтийг шийдвэрлэж, сайн дурын даатгалын хувийн хэрэг, холбогдох баримт бичгийг шилжүүлсэн нийгмийн даатгалын байгууллагын архивт хадгална.

4.15.Энэ журмын 4.14-т заасны дагуу шилжиж ирсэн даатгуулагчийн гэрээнд тусгагдсан мэдээлэл, шимтгэл төлөлтийн тооцоог шалгасны дараа түүнийг өмнөх гэрээнд заасан нөхцөлөөр нь шимтгэлийг үргэлжлүүлэн төлүүлж, шилжиж ирсэн нийгмийн даатгалын байгууллага (байцаагч) хувийн хэрэг нээж холбогдох тооцоог хийнэ.

## Тав. Даатгуулагчийн шимтгэл төлөх сарын цалин хөлс, шимтгэл төлөх хувь хэмжээ, илүү төлсөн шимтгэлийн зохицуулалт

5.1.Нийгмийн даатгалын байгууллагатай гэрээ байгуулж буй энэ журмын 2.1-д заасан даатгуулагч нь Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1-д заасны дагуу өөрөө мэдүүлсэн цалин хөлснөөс шимтгэл төлнө.

5.1.1.Сайн дураар даатгуулагчийн шимтгэл төлөх, тэтгэвэр, тэтгэмж тогтоолгох сарын цалин хөлсний доод хэмжээ нь тухайн мөрдөж байгаа сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс багагүй, дээд хэмжээ нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 7 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцүү байна.

5.2.Гэрээний хугацаанд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт Үндэсний хорооноос шинэчлэн тогтоосон тохиолдолд уг шийдвэр хэрэгжих хугацаанаас нь эхлэн шимтгэл төлөх цалин хөлсний орлогын доод хэмжээг өөрчилж, энэ талаар даатгуулагчид мэдэгдэнэ.

5.3.Даатгуулагч гэрээгээр тохирсон, өөрийн мэдүүлсэн сарын цалин хөлснөөс Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 18 дугаар зүйлийн 18.3 дахь хэсэгт заасан хувь хэмжээгээр нийгмийн даатгалын шимтгэлийг сар бүр төлөх үүрэг хүлээнэ.

5.4.Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 18 дугаар зүйлийн 18.3-т заасан шимтгэлийн хувь хэмжээ өөрчлөгдөх тохиолдолд уг хувь хэмжээ хэрэгжиж эхлэх хугацаанаас эхлэн төлөх шимтгэлийн хэмжээг өөрчлөгдсөн хувиар тооцно.

5.5.Гэрээг дуусах хүртэл хугацаанд энэ журмын 5.2, 5.3-т заасанаас бусад тохиолдолд гэрээгээр тохирсон цалин хөлс, шимтгэлийн хувь хэмжээг өөрчлөхгүй.

5.6.Энэ журмын 2.1.2, 2.1.4-т заасан даатгуулагчийн цалин хөлсний хэмжээг гэрээ байгуулснаас хойш 12 сар тутамд нэг удаа өөрчилж болно.

5.7.Доор дурдсан даатгуулагчийн өөрөө төлөх шимтгэлийг дараах байдлаар тодорхойлно:

5.7.1.гурав хүртэлх насны хүүхдээ асарч байгаа даатгуулагч эх хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс шимтгэл төлөх тохиолдолд тэтгэвэр, тэтгэмжийн даатгалын шимтгэлийн 50 хувийг тэтгэмжийн даатгалын сан болон улсын төсвөөс, тэтгэвэр, тэтгэмжийн даатгалын шимтгэлийн үлдэх 50 хувь болон үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын шимтгэлийг даатгуулагч өөрөө бүрэн хариуцан тус тус төлнө.

5.7.2.гурав хүртэлх насны хүүхдээ асарч байгаа даатгуулагч эх хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс дээш орлогоос шимтгэл төлөх бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс тооцсон тэтгэмжийн даатгалын сан болон улсын төсвөөс хариуцан төлөх тэтгэвэр, тэтгэмжийн даатгалын шимтгэлийн 50 хувийг хассан дүнгээр буюу тэтгэвэр, тэтгэмжийн даатгалын шимтгэлийн зөрүү, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын шимтгэлийг өөрөө бүрэн хариуцан төлнө.

5.7.3.малчин, туслах малчин хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс шимтгэл төлөх тохиолдолд тэтгэврийн даатгалын шимтгэлийн 50 хувийг улсын төсвөөс, тэтгэврийн даатгалын шимтгэлийн үлдэх 50 хувь болон тэтгэмж, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын шимтгэлийг даатгуулагч өөрөө бүрэн хариуцан тус тус төлнө.

5.7.4.малчин, туслах малчин хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс дээш орлогоос шимтгэл төлөх бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс тооцсон улсын төсвөөс хариуцан төлөх тэтгэврийн даатгалын шимтгэлийн 50 хувийг хассан дүнгээр буюу тэтгэврийн даатгалын шимтгэлийн зөрүү болон тэтгэмж, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын шимтгэлийг өөрөө бүрэн хариуцан төлнө.

5.7.5.эмнэлгийн хяналтад байдаг, байнгын асаргаа шаардлагатай 18 хүртэлх насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч байгаа ажил хөдөлмөр эрхлээгүй эх, эсхүл эцэг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс шимтгэл төлөх тохиолдолд тэтгэврийн даатгалын шимтгэлийг улсын төсвөөс бүрэн, тэтгэмжийн, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын шимтгэлийг даатгуулагч өөрөө бүрэн хариуцан тус тус төлнө.

5.7.6.эмнэлгийн хяналтад байдаг, байнгын асаргаа шаардлагатай 18 хүртэлх насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч байгаа ажил хөдөлмөр эрхлээгүй эх, эсхүл эцэг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс дээш орлогоос шимтгэл төлөх бол улсын төсвөөс төлөх хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс тооцсон тэтгэврийн даатгалын шимтгэлийг хассан дүнгээр буюу тэтгэврийн даатгалын шимтгэлийн зөрүү болон тэтгэмжийн, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын шимтгэлийг өөрөө бүрэн хариуцан төлнө.

5.8.Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 7 дугаар зүйлийн 7.10-т заасны дагуу сайн дураар даатгуулсан хугацаанд Иргэний хуулийн 343, 359 дүгээр зүйлд заасан ажил гүйцэтгэх, хөлсөөр ажиллах гэрээ болон тэдгээртэй адилтгах гэрээгээр ажилласан бол албан журмаар даатгуулж давхар шимтгэл төлж болно.

5.9.Энэ журмын 5.8-д зааснаас бусад тохиолдолд албан журмын даатгалтай давхардуулан сайн дураар даатгуулахгүй.

5.10.Сайн дурын даатгалд даатгуулсан хугацаанд хөдөлмөрийн гэрээгээр ажилласан тохиолдолд сайн дурын даатгалын шимтгэлийг даатгуулагчид буцаан олгоно. Даатгуулагчийн илүү төлсөн шимтгэлийг буцаан олгох, эсхүл дараагийн сар, улирал, жилийн төлбөл зохих шимтгэлд шилжүүлэн тооцоход нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас баталсан "Илүү төлсөн шимтгэлийг буцаан олгох харилцааг зохицуулсан журам"-ыг баримтална.

## Зургаа. Гэрээ дуусгавар болгох, цуцлах, хүчингүйд тооцох

6.1.Сайн дурын даатгалын гэрээний хугацаа 12 сар байна.

6.2.Даатгуулагчийн гэрээний хугацаа дараах тохиолдолд дуусгавар болно:

6.2.1.гэрээгээр тохирсон хугацаа дуусгавар болсон;

6.2.2.өндөр насны тэтгэвэр тогтоолгосон сараас;

6.2.3.даатгуулагч гэрээний хугацааг дуустал хугацаагаар хөдөлмөрийн гэрээгээр ажил хөдөлмөр эрхэлсэн бол тухайн сараас;

6.2.4.даатгуулагч эхийн хүүхэд нь 3 нас хүрээгүй байхдаа бусдад үрчлэгдсэн, нас барсан эсхүл 3 нас хүрсэн бол түүний дараагийн сараас;

6.2.5.энэ журмын 2.1.3-т заасан даатгуулагч малчнаас өөр хэлбэрээр ажил эрхэлсэн сараас;

6.2.6.туслах малчны гэрээ цуцлагдсан, гэрээний хугацаа дууссан дараагийн сараас;

6.2.7.энэ журмын 2.1.4-т заасан даатгуулагчийн байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тодорхойлолтын хугацаа дуусгавар болсон, цуцлагдсан, 18 нас хүрсэн эсхүл 18 нас хүрээгүй байхдаа бусдад үрчлэгдсэн, нас барсан бол түүний дараагийн сараас;

6.2.8.даатгуулагч нас барсан сараас.

6.3.Нийгмийн даатгалд сайн дураар даатгуулах гэрээг дараах тохиолдолд хүчингүйд тооцно:

6.3.1.гэрээг хуурамчаар үйлдсэн нь тогтоогдсон бол;

6.3.2.гэрээг 2 талын аль нэг нь зөвшөөрөөгүй бол;

6.3.3.иргэний хуульд заасан бусад нөхцөл үүссэн бол.

## Долоо.Нийгмийн даатгалын байгууллага (байцаагч)-ийн эрх, үүрэг

7.1.Нийгмийн даатгалын байгууллага (байцаагч) нь байгуулсан гэрээ болон гэрээний сунгалт хүчин төгөлдөр болсон сараас эхлэн нийгмийн даатгалын шимтгэлийг бүрэн төлж буй эсэхэд хяналт тавих бөгөөд шимтгэлийн төлбөрийг бэлэн бусаар төлүүлнэ.

7.2.Нийгмийн даатгалын байгууллага (байцаагч) нь сайн дураар даатгуулах болон гэрээний хугацааг сунгуулах тухай хүсэлтээ гаргасан даатгуулагч (иргэн)-ийг уг хүсэлт гаргасан сарын шимтгэлээ нийгмийн даатгалын сангийн харилцах дансанд төлсөн тохиолдолд түүнтэй нийгмийн даатгалд сайн дураар даатгуулсан тухай гэрээг хэрэгжиж эхэлсэнд тооцож, нийгмийн даатгалын мэдээллийн нэгдсэн санд бүртгэж, шимтгэл төлөлтийн тооцоог хийж хянасны үндсэн дээр баталгаажуулна.

7.3.Даатгуулагч шимтгэлээ гэрээгээр тохирсон хугацаандаа төлөөгүй, эсвэл дутуу төлсөн тохиолдолд Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 44.1.2-т заасны дагуу дутуу төлсөн буюу хугацаандаа төлөөгүй нийгмийн даатгалын шимтгэлийг

нөхөн төлүүлж, уг шимтгэлийн дүнгээс хугацаа хэтрүүлсэн хоног тутамд 0.3 хувийн алданги ногдуулна. Өмнө нь дуусгавар болсон гэрээний хугацаанд шимтгэлээ бүрэн төлөөгүй даатгуулагчийн тухайн төлөгдөөгүй хугацааны шимтгэлийг нөхөн төлүүлэхгүй.

7.4.Тухайн жилд гэрээний маягт шинэчлэн батлагдсан тохиолдолд өмнө нь байгуулсан гэрээний хугацаанд гэрээг хуучин маягтаар нь үргэлжлүүлнэ. Харин гэрээг сунгах эсхүл гэрээний хугацаа дууссан бол шинэ маягтын дагуу даатгуулагчтай гэрээг шинээр байгуулна.

7.5.Нийгмийн даатгалын байгууллага нь гэрээний хугацаа нь дуусаж, сунгалт хийгдээгүй, өндөр насны тэтгэвэр тогтоолгосон, нас барсан сайн дураар даатгуулагчийн гэрээг дуусгавар болгож, шимтгэл төлөлтийн тооцоог эцэслэн дуусгаж, хувийн хэрэг, холбогдох баримт бичгийг архивт шилжүүлэн хадгална.

7.6.Сайн дурын даатгалд даатгуулсан хугацаанд хөдөлмөрийн гэрээгээр ажилласан тохиолдолд сайн дурын даатгалын шимтгэлийг даатгуулагчид буцаан олгоно. Даатгуулагчийн илүү төлсөн шимтгэлийг буцаан олгох, эсхүл дараагийн сар, улирал, жилийн төлбөл зохих шимтгэлд шилжүүлэн тооцоход нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас баталсан “Илүү төлсөн шимтгэлийг буцаан олгох харилцааг зохицуулсан журам”-ыг баримтална.

7.7.Гэрээний хугацаанд нийгмийн даатгалын байгууллага хооронд шилжих хүсэлт гаргасан даатгуулагчийн шимтгэл төлөлтийн тооцоог бүрэн хийснээр уг хүсэлтийг шийдвэрлэж, сайн дурын даатгалын хувийн хэрэг, холбогдох баримт бичгийг шилжүүлсэн нийгмийн даатгалын байгууллагын архивт хадгална.

7.8.Даатгуулагч урьд нь байгуулсан гэрээний хугацаа дуусахаас өмнө нийгмийн даатгалын байгууллага хооронд шилжиж ирсэн тохиолдолд даатгуулагчийг өмнөх гэрээнд заасан нөхцөлөөр нь шимтгэлийг үргэлжлүүлэн төлүүлж, шилжиж ирсэн нийгмийн даатгалын байгууллага (байцаагч) хувийн хэрэг нээж холбогдох тооцоог хийнэ.

7.9.Нийгмийн даатгалын байгууллага (байцаагч) нь даатгуулагчийн төлөх нийгмийн даатгалын шимтгэлийг бэлэн мөнгөөр авахыг хориглоно.

## Найм.Даатгуулагчийн эрх, үүрэг

8.1.Даатгуулагч нь гэрээний хугацаанд мөрдөгдөх нийгмийн даатгалын шимтгэл тооцох сарын цалин хөлсөө өөрөө тодорхойлж, түүнд ногдох шимтгэлийг бэлэн бусаар нийгмийн даатгалын санд төлнө.

8.2.Даатгуулагч шимтгэлээ гэрээгээр тохирсон хугацаандаа төлөөгүй, эсвэл дутуу төлсөн тохиолдолд Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 44.1.2-т заасны дагуу дутуу төлсөн буюу хугацаандаа төлөөгүй, дутуу төлсөн нийгмийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлж, уг шимтгэлийн дүнгээс хугацаа хэтрүүлсэн хоног тутамд

ТУ3834
9132155
119277797

0.3 хувийн алданги төлнө. Өмнө нь дуусгавар болсон гэрээний хугацаанд шимтгэлээ бүрэн төлөөгүй даатгуулагчийн тухайн төлөгдөөгүй хугацааны шимтгэлийг нөхөн төлүүлэхгүй.

8.3.Гэрээний хугацаанд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ өөрчлөгдөн батлагдаж хэрэгжиж эхлэх хугацаанаас даатгуулагчийн мэдүүлсэн шимтгэл төлөх сарын цалин хөлс нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс бага тохиолдолд даатгуулагч нь гэрээгээр тохирсон шимтгэл ногдуулж төлөх сарын цалин хөлс, түүнтэй адилтгах орлогыг шинэчлэн батлагдсан хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр өөрчлүүлж, үүнээс үүссэн шимтгэлийн зөрүүг даатгалын санд нөхөж төлнө.

8.4.Сайн дурын даатгуулагч нь Иргэний хуулийн 343, 359 дүгээр зүйлд заасан ажил гүйцэтгэх, хөлсөөр ажиллах гэрээ болон тэдгээртэй адилтгах гэрээгээр ажилласан бол албан журмаар даатгуулж давхар шимтгэл төлж болно. Бусад тохиолдолд албан журмын даатгалтай давхардуулан сайн дураар даатгуулахгүй.

8.5.Даатгуулагч Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуульд заасан болзол, нөхцөлийг хангасан бол тэтгэвэр, тэтгэмж, эрүүл мэндийн нөхөн сэргээлтийн зардлын төлбөр авах эрхтэй.

8.6.Даатгуулагч гэрээний хүчинтэй хугацаанд Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 7 дугаар зүйлийн 7.2-7.5-д заасан албан журмаар даатгуулж ажилласан боловч гэрээний хугацаа дуусахаас өмнө албан журмын харилцаа дуусгавар болсон бол уг гэрээг үргэлжлүүлэн нийгмийн даатгалын шимтгэл төлж, даатгуулж болно. Хэрэв сайн дурын даатгалын гэрээний хугацаа дуусахад албан журмаар даатгуулагчийн харилцаа үргэлжилсэн хэвээр байвал гэрээг үргэлжлүүлэн сунгахгүй, гэрээний хүчинтэй хугацаагаар дуусгавар болсонд тооцно.

8.7.Даатгуулагч нийгмийн даатгалд сайн дураар даатгуулсан тухай мэдээллийг ил тод, түргэн шуурхай авах эрхтэй.

## Ес.Тайлан гаргах, хяналт тавих

9.1.Нийгмийн даатгалд сайн дураар даатгуулах гэрээний үндэслэл, баталгаажуулалт, гэрээгээр хүлээсэн үүргийн биелэлт, шимтгэл төлөлт зэрэгт аймаг, дүүргийн нийгмийн даатгалын газрын хяналт хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий нэгж, ажилтан, хариуцсан байцаагч хяналт тавина.

9.2.Нийгмийн даатгалын байгууллага (байцаагч) нь энэ журмын 2.1-д заасан даатгуулагчийн шимтгэл төлөлтийн сарын тооцоог хийж тайлан гаргахын өмнө доор дурдсан асуудлуудын үндэслэлийг шалгаж шийдвэрлэсэн байна:

9.2.1.даатгуулагчтай байгуулсан гэрээ нь эрх зүйн үндэслэлтэй эсэх;

ТУ3894
9132155
1119277787

9.2.2.гэрээнд тусгагдсан шимтгэлийн тооцоог мэдээллийн санд бүрэн оруулж бүртгэж, баталгаажуулсан эсэх;

9.2.3.гэрээний хугацаа сунгагдсан, дуусгавар болоогүй байгаа эсэх;

9.2.4.нийгмийн даатгалын сангийн харилцах дансанд төлсөн шимтгэл нь тухайн даатгуулагчийн иргэний бүртгэлийн дугаараар бүртгэгдсэн эсэх;

9.2.5.гэрээнд заасан хугацаанд шимтгэлээ бүрэн төлсөн эсэх;

9.2.6.гэрээний хугацаанд албан журмын даатгалд даатгуулж, давхар цалин хөлс, түүнтэй адилтгах орлого авч шимтгэл төлсөн тохиолдолд тооцооллыг зөв хийсэн эсэх.

9.3.Нийгмийн даатгалын байгууллага нь даатгуулагчийн илүү болон дутуу төлсөн шимтгэлийн тооцоог энэ журмын 9.2-т заасны дагуу хийж, тайланг хагас, бүтэн жилээр гарган нэгтгэж, эрх бүхий ажилтнаар баталгаажуулан нийгмийн даатгалын сангийн санхүүгийн тайланд хавсаргана.

9.4.Нийгмийн даатгалын байцаагч даатгуулагчийн шимтгэл төлөлтийн тайлан, жагсаалтыг жилээр хэвлэн эрх бүхий ажилтнаар баталгаажуулан, архивын нэгж үүсгэн архивт хүлээлгэн өгнө.

## Арав.Маргаан шийдвэрлэх

10.1.Энэ журмыг хэрэгжүүлэхтэй холбогдсон маргаантай асуудлыг хоёр тал харилцан зөвшилцөн шийдвэрлэх зарчим баримтлах бөгөөд шаардлагатай бол Маргаан хянан шийдвэрлэх зөвлөл, эсхүл шүүхээр шийдвэрлүүлнэ.

## Арав нэг.Хариуцлага

11.1.Энэ журмын 2.1-д заасан даатгуулагч шимтгэлээ гэрээгээр тохирсон хугацаандаа төлөөгүй, эсхүл дутуу төлсөн бол төлбөл зохих шимтгэлийг нөхөн төлүүлж, уг шимтгэлийн дүнгээс хугацаа хэтрүүлсэн хоног тутамд 0.3 хувийн алданги тооцон төлүүлнэ. Алдангийн хэмжээ нь төлбөл зохих нийгмийн даатгалын шимтгэлийн 50 хувиас хэтрэхгүй байна.

11.2.Даатгуулагчийн хүчинтэй гэрээний хугацаанд энэ журмын 11.1 дэх заалтыг хэрэглэх бөгөөд өмнө нь дуусгавар болсон гэрээний төлөгдөөгүй хугацааны шимтгэлд хамааруулахгүй, алданги тооцож, нөхөн төлүүлэхгүй.

11.3.Энэхүү журмыг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

---o0o---

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ
ХУУЛБАР ҮНЭН
Гарын үсэг:
2021 оны 12 сарын 28 өдөр

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн А/210 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

## НИЙГМИЙН ДААТГАЛД САЙН ДУРААР ДААТГУУЛСАН ТУХАЙ ГЭРЭЭ

Дугаар .....................

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэгт заасны дагуу нийгмийн даатгалд сайн дураар даатгахаар нэг талаас................................ аймаг (хот)-ийн ................................ дүүрэг (сум)-ийн нийгмийн даатгалын газар (тасаг)-ийг төлөөлж, байцаагч ................................ эцэг (эх)-ийн нэр ................................өөрийн нэр (цаашид “нийгмийн даатгалын байгууллага (байцаагч)” гэх), нөгөө талаас иргэн .........................эцэг (эх)-ийн нэр ......................... өөрийн нэр (цаашид “даатгуулагч” гэх) нар (цаашид “талууд” гэх) харилцан тохиролцож энэхүү гэрээг байгуулав.

1.2.Даатгуулагчийн иргэний бүртгэлийн дугаар:

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | |

1.3.Даатгуулагчийн хөдөлмөр эрхлэлтийн байдал: (тохирох хэсгийн ард (√) тэмдэглэнэ)

| | | |
|---|---|---|
| 1 | Хувиараа хөдөлмөр эрхлэгч | |
| 2 | Жолооч | |
| | такси | |
| | зорчигч тээврийн | |
| | ачаа, хот хоорондын тээврийн | |
| 3 | Бичил уурхай эрхлэгч | |
| 4 | Газар тариалан эрхлэгч (ногоочин) | |
| 5 | Төрөөс олгох урамшуулалд хамрагдсан иргэн | |
| 6 | Хөдөлмөрийн чадвараа алдсан хүн | |
| 7 | Оюутан суралцагч | |
| 8 | Гэрийн үйлчилгээний болон түүнтэй адилтгах ажилтан | |
| 9 | Цалингүй нэг ба түүнээс дээш сарын захиргааны чөлөө авсан ажилтан | |
| 10 | Гадаад улсад ажиллаж, амьдарч байгаа Монгол Улсын иргэн | |
| 11 | Монгол улсад амьдарч байгаа гадаадын иргэн, харьяалалгүй хүн | |
| 12 | Бусад | |

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ
ХУУЛБАР ҮНЭН
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ГАЗАР
Гарын үсэг:
2023 оны 12 сарын 25 өдөр

Нийгмийн даатгалын шимтгэл ногдуулж төлөх
орлогын хэмжээ, хувь, хугацаа

1.4.Гэрээний хугацаа нь 1-12 сар байна: ......... сар

1.5.Гэрээний хүчинтэй байх хугацаа: ......................... ............................
/эхлэх/ (он, сар, өдөр) /дуусах/ (он, сар, өдөр)

1.6.Нийгмийн даатгалын шимтгэл ногдуулж төлөх сарын цалин хөлс, түүнтэй адилтгах орлого ..................... төгрөг.
Түүнд ногдуулж сар бүр төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн дүн: ................ төгрөг байна.

1.6.1.Даатгуулагчийн энэхүү гэрээний 1.6-д заасан өөрөө мэдүүлсэн шимтгэл төлөх, тэтгэвэр, тэтгэмж тогтооход баримтлах сарын цалин хөлсний доод хэмжээ нь тухайн үед мөрдөж байгаа сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс багагүй, дээд хэмжээ нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 7 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцүү байна. Гэрээний хугацаанд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ эрх бүхий байгууллагын шийдвэрээр шинэчлэн тогтоогдсон тохиолдолд уг шийдвэрийг хэрэгжих хугацаанаас нь эхлэн дагаж, мөрдөнө.

1.6.2.Гэрээний 1.6-д заасан орлого нь шинэчлэн баталсан хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс бага тохиолдолд уг шийдвэрийг дагаж мөрдөх хугацаанаас эхлэн өөрчлөгдсөн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр, дээд хэмжээ нь багассан тохиолдолд шинэчлэгдсэн дээд хэмжээгээр өөрчлөгдсөнд тооцно.

1.6.3.Энэ гэрээний 1.6-д заасан нийгмийн даатгалын шимтгэл ногдуулж, төлж буй сарын цалин хөлсний хэмжээ нь энэхүү гэрээний 1.6.2-т зааснаас бусад тохиолдолд өөрчлөгдөхгүй.

1.7.Энэ гэрээний 1.6-д заасан сарын цалин хөлснөөс тэтгэврийн даатгалын санд 11.5 хувь, тэтгэмжийн даатгалын санд 1.0 хувь, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын санд 1.0 хувиар тооцож нийт 13.5 хувийн нийгмийн даатгалын шимтгэл төлнө.

1.8.Гэрээний хугацаанд Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт өөрчлөлт орж, энэ гэрээний 1.7-д заасан шимтгэлийн хувь хэмжээ өөрчлөгдсөн тохиолдолд уг хуулийн хэрэгжих хугацаанаас эхлэн шинээр тогтоосон хувь хэмжээгээр тооцож шимтгэлийг төлөх бөгөөд үүнээс үүсэх шимтгэлийн зөрүүг тухайн даатгуулагч хариуцаж санд нөхөн төлнө.

1.9.Даатгуулагч энэ гэрээний 1.6-д заасан цалин хөлснөөс мөн гэрээний 1.7-д заасан хувь хэмжээгээр тооцсон нийгмийн даатгалын шимтгэлийг даатгалын санд сар бүр төлөх үүрэг хүлээх бөгөөд урьдчилан төлж болно.

1.10.Гэрээг цаасаар болон цахим хэлбэрээр байгуулж, сунгаж болно.

1.11.Даатгуулагч гэрээг байгуулах хүсэлтийн дагуу сард ногдох шимтгэлээ төлснөөр, төлбөр төлсөн сараас эхлэн уг гэрээг хэрэгжиж эхэлсэнд тооцно. (Гэрээний сунгалт, өөрчлөлт нэгэн адил хамаарна).

1.12.Даатгуулагч энэхүү гэрээнд заасан төлбөл зохих нийгмийн даатгалын шимтгэлээ санд бүрэн төлж дууссан тохиолдолд гэрээний хугацааг сунгуулах тухай хүсэлтээ нийгмийн даатгалын байгууллага (байцаагч)-д өөрийн биеэр эсхүл цахимаар гаргаж болно.

1.13.Даатгуулагч өмнө нь байгуулсан гэрээний хугацаа дууссаны дараагийн сард багтаан шимтгэл төлсөн тохиолдолд гэрээний хугацааг өмнөх гэрээний нөхцөлөөр үргэлжлүүлэн сунгасанд тооцно. Даатгуулагч өмнө нь байгуулсан гэрээний нөхцөлөө өөрчлөх тохиолдолд хүсэлтээ нийгмийн даатгалын байгууллагад гаргаж холбогдох өөрчлөлтийг тусган гэрээний хугацааг сунгана.

1.14.Даатгуулагч гэрээний хугацаагаа сунгах хүсэлт гаргасан боловч өмнөх гэрээ дууссанаас хойш 1 ба түүнээс дээш сарын дараа шимтгэл төлсөн бол шимтгэл төлсөн сараас нь эхлэн гэрээг шинээр байгуулсанд тооцно. Гэрээг шимтгэл төлсөн сараас эхлэн үргэлжлүүлэн баталгаажуулж, уг шимтгэлийг нь зохих саруудад бүртгэж, нийгмийн даатгалын мэдээллийн нэгдсэн санд оруулна.

1.15.Нийгмийн даатгалын байгууллага (байцаагч) нь батлагдсан маягтын дагуу даатгуулагчтай байгуулсан гэрээг 2 хувь үйлдэж, нийгмийн даатгалын байцаагч, даатгуулагч тус тус гарын үсэг зурснаар уг гэрээ баталгаажна. Даатгуулагч цахимаар гэрээ байгуулж буй тохиолдолд гэрээний нөхцөлтэйгөө танилцаж, "гэрээний нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна" сонголтыг сонгосноор байцаагч болон даатгуулагчийг уг гэрээнд гарын үсэг зурж, баталгаажуулснаар тооцно.

## Хоёр.Нийгмийн даатгалын байгууллага (байцаагч)-ийн эрх, хүлээх үүрэг

2.1.Нийгмийн даатгалын байгууллага (байцаагч) нь байгуулсан гэрээ болон гэрээний сунгалт хүчин төгөлдөр болсон сараас эхлэн нийгмийн даатгалын шимтгэлийг бүрэн төлж буй эсэхэд хяналт тавих бөгөөд шимтгэлийн төлбөрийг бэлэн бусаар төлүүлнэ.

2.2.Нийгмийн даатгалын байгууллага (байцаагч) нь сайн дураар даатгуулах болон гэрээний хугацааг сунгуулах тухай хүсэлтээ гаргасан даатгуулагч (иргэн)-ийг уг хүсэлт гаргасан сарын шимтгэлээ нийгмийн даатгалын сангийн харилцах дансанд төлсөн тохиолдолд түүнтэй нийгмийн даатгалд сайн дураар даатгуулсан тухай гэрээг хэрэгжиж эхэлсэнд тооцож, нийгмийн даатгалын мэдээллийн нэгдсэн санд бүртгэж, шимтгэл төлөлтийн тооцоог хийж хянасны үндсэн дээр баталгаажуулна.

2.3.Даатгуулагч шимтгэлээ энэ гэрээний 1.9-д тохирсон хугацаандаа төлөөгүй, эсвэл дутуу төлсөн тохиолдолд Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн

9132155
1119277787

44.1.2-т заасны дагуу дутуу төлсөн буюу хугацаандаа төлөөгүй нийгмийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлж, уг шимтгэлийн дүнгээс хугацаа хэтрүүлсэн хоног тутамд 0.3 хувийн алданги ногдуулна. Өмнө нь дуусгавар болсон гэрээний хугацаанд шимтгэлээ бүрэн төлөөгүй даатгуулагчийн тухайн төлөгдөөгүй хугацааны шимтгэлийг нөхөн төлүүлэхгүй.

2.4.Тухайн жилд гэрээний маягт шинэчлэн батлагдсан тохиолдолд өмнө нь байгуулсан гэрээний хугацаанд гэрээг хуучин маягтаар нь үргэлжлүүлнэ. Харин гэрээг сунгах эсхүл гэрээний хугацаа дууссан бол шинэ маягтын дагуу даатгуулагчтай гэрээг шинээр байгуулна.

2.5.Нийгмийн даатгалын байгууллага нь гэрээний хугацаа нь дуусаж, сунгалт хийгдээгүй, өндөр насны тэтгэвэр тогтоолгосон, нас барсан сайн дураар даатгуулагчийн гэрээг дуусгавар болгож, шимтгэл төлөлтийн тооцоог эцэслэн дуусгаж, хувийн хэрэг, холбогдох баримт бичгийг архивт шилжүүлэн хадгална.

2.6.Сайн дурын даатгалд даатгуулсан хугацаанд хөдөлмөрийн гэрээгээр ажилласан тохиолдолд сайн дурын даатгалын шимтгэлийг даатгуулагчид буцаан олгоно. Даатгуулагчийн илүү төлсөн шимтгэлийг буцаан олгох, эсхүл дараагийн сар, улирал, жилийн төлбөл зохих шимтгэлд шилжүүлэн тооцоход нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас баталсан “Илүү төлсөн шимтгэлийг буцаан олгох харилцааг зохицуулсан журам”-ыг баримтална.

2.7.Гэрээний хугацаанд нийгмийн даатгалын байгууллага хооронд шилжих хүсэлт гаргасан даатгуулагчийн шимтгэл төлөлтийн тооцоог бүрэн хийснээр уг хүсэлтийг шийдвэрлэж, сайн дурын даатгалын хувийн хэрэг, холбогдох баримт бичгийг шилжүүлсэн нийгмийн даатгалын байгууллагын архивт хадгална.

2.8.Даатгуулагч урьд нь байгуулсан гэрээний хугацаа дуусахаас өмнө нийгмийн даатгалын байгууллага хооронд шилжиж ирсэн тохиолдолд даатгуулагчийг өмнөх гэрээнд заасан нөхцөлөөр нь шимтгэлийг үргэлжлүүлэн төлүүлж, шилжиж ирсэн нийгмийн даатгалын байгууллага (байцаагч) хувийн хэрэг нээж холбогдох тооцоог хийнэ.

2.9.Нийгмийн даатгалын байгууллага (байцаагч) нь даатгуулагчийн төлөх нийгмийн даатгалын шимтгэлийг бэлэн мөнгөөр авахыг хориглоно.

Гурав.Даатгуулагчийн эрх, үүрэг

3.1.Даатгуулагч нь гэрээний хугацаанд мөрдөгдөх нийгмийн даатгалын шимтгэл тооцох сарын хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоо өөрөө тодорхойлж, түүнд ногдох шимтгэлийг энэхүү гэрээний 1.7-д заасан хувь хэмжээгээр тооцож, 1.9-д заасан хугацаагаар бэлэн бусаар нийгмийн даатгалын санд төлнө.

3.2.Даатгуулагч шимтгэлээ энэ гэрээний 1.9-д заасан хугацаандаа төлөөгүй, эсвэл дутуу төлсөн тохиолдолд Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 44.1.2-т

заасны дагуу дутуу төлсөн буюу хугацаандаа төлөөгүй, дутуу төлсөн нийгмийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлж, уг шимтгэлийн дүнгээс хугацаа хэтрүүлсэн хоног тутамд 0.3 хувийн алданги төлнө. Өмнө нь дуусгавар болсон гэрээний хугацаанд шимтгэлээ бүрэн төлөөгүй даатгуулагчийн тухайн төлөгдөөгүй хугацааны шимтгэлийг нөхөн төлүүлэхгүй.

3.3.Гэрээний хугацаанд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ өөрчлөгдөн батлагдаж хэрэгжиж эхлэх хугацаанаас даатгуулагчийн мэдүүлсэн шимтгэл төлөх сарын цалин хөлс нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс бага тохиолдолд даатгуулагч нь гэрээний 1.6-д заасан шимтгэл ногдуулж төлөх сарын цалин хөлсийг шинэчлэн батлагдсан хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр өөрчлүүлж, үүнээс үүссэн шимтгэлийн зөрүүг даатгалын санд нөхөж төлнө.

3.4.Сайн дурын даатгуулагч нь Иргэний хуулийн 343, 359 дүгээр зүйлд заасан ажил гүйцэтгэх, хөлсөөр ажиллах гэрээ болон тэдгээртэй адилтгах гэрээгээр ажилласан бол албан журмаар даатгуулж давхар шимтгэл төлж болно. Бусад тохиолдолд албан журмын даатгалтай давхардуулан сайн дураар даатгуулахгүй.

3.5.Даатгуулагч Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуульд заасан болзол, нөхцөлийг хангасан бол тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, зардал авах эрхтэй.

3.6.Даатгуулагч гэрээний хүчинтэй хугацаанд Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 7 дугаар зүйлийн 7.2-7.5-д заасан албан журмаар даатгуулж ажилласан боловч энэхүү гэрээний 1.5-д заасан хугацаа дуусахаас өмнө албан журмын харилцаа дуусгавар болсон бол уг гэрээг үргэлжлүүлэн нийгмийн даатгалын шимтгэл төлж, даатгуулж болно. Хэрэв сайн дурын даатгалын гэрээний хугацаа дуусахад албан журмаар даатгуулагчийн харилцаа үргэлжилсэн хэвээр байвал гэрээг үргэлжлүүлэн сунгахгүй, 1.5-д заасан хугацаагаар дуусгавар болсонд тооцно.

## Дөрөв.Гэрээ дуусгавар болгох, хүчингүйд тооцох

4.1.Даатгуулагчийн гэрээний хугацаа дараах тохиолдолд дуусгавар болно:

4.1.1.гэрээгээр тохирсон хугацаа дуусгавар болсон;

4.1.2.өндөр насны тэтгэвэр тогтоолгосон сараас;

4.1.3.даатгуулагч гэрээний хугацаа дуустал хугацаагаар хөдөлмөрийн гэрээгээр ажил хөдөлмөр эрхэлсэн бол тухайн сараас;

4.1.4.даатгуулагч нас барсан сараас.

4.2.Нийгмийн даатгалд сайн дураар даатгуулах гэрээг дараах тохиолдолд хүчингүйд тооцно:

4.2.1.гэрээг хуурамчаар үйлдсэн нь тогтоогдсон бол;

4.2.2.гэрээг 2 талын аль нэг нь зөвшөөрөөгүй бол.

ТУ3894
9132155
19277787

4.3.Даатгуулагч гэрээний хугацаандаа гурав хүртэлх насны хүүхдээ асарч буй эх, малчин, туслах малчин, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч байгаа ажил хөдөлмөр эрхлээгүй эх /эцэг/-ийн даатгуулагчийн нөхцөлөөр даатгуулах хүсэлт гаргасан тохиолдолд түүний гэрээг шинэчлэн байгуулна. Энэ тохиолдолд өмнөх гэрээний шимтгэл төлөлтийн тооцоог бүрэн барагдуулж, гэрээг дуусгавар болгоно.

## Тав. Маргааныг шийдвэрлэх, хүлээх хариуцлага

5.1.Гэрээг хэрэгжүүлэхтэй холбогдсон маргаантай асуудлыг хоёр тал харилцан зөвшилцөн шийдвэрлэх зарчим баримтлах бөгөөд шаардлагатай бол Маргаан хянан шийдвэрлэх зөвлөл, эсхүл шүүхээр шийдвэрлүүлнэ.

5.2.Энэхүү гэрээгээр хүлээсэн үүрэг болон нийгмийн даатгалын хууль тогтоомжийг зөрчвөл холбогдох хуульд заасны дагуу зохих хариуцлага хүлээнэ.

## Зургаа.Бусад

6.1.Энэхүү гэрээг хоёр хувь үйлдэж нэг хувийг Нийгмийн даатгалын байгууллагад, нөгөө хувийг гэрээ байгуулсан даатгуулагчид өгөх ба хувь тус бүр хүчин төгөлдөр байна.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

| Нийгмийн даатгалын байгууллагыг төлөөлж: | Сайн дураар даатгуулагчийг төлөөлж: |
| --- | --- |
| ................................аймаг /дүүрэг/, | ..................................... аймаг /дүүрэг/, |
| сумын нийгмийн даатгалын байцаагч | сумын ..........................хороо /баг/-ын оршин суугч |
| ........................ / ........................./ | ......................... / ............................./ |
| /гарын үсэг/ /гарын үсгийн тайлал/ | /гарын үсэг/ /гарын үсгийн тайлал/ |
| Утас: ................... | Утас: ..................... Утас:.................... |
| Э-шуудангийн хаяг: ..................... | Э-шуудангийн хаяг: .......................... |
| 202 . . . оны . . . сарын . . . өдөр | 202 . . . оны . . . сарын . . . өдөр |

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ
ХУУЛБАР ҮНЭН
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ГАЗРЫН ДАРГА
Гарын үсэг
20.. он .. сар .. өдөр

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн А/200 дугаар тушаалын гуравдугаар хавсралт

## ГУРАВ ХҮРТЭЛХ НАСНЫ ХҮҮХДЭЭ АСАРЧ БУЙ ЭХИЙН НИЙГМИЙН ДААТГАЛД САЙН ДУРААР ДААТГУУЛСАН ТУХАЙ ГЭРЭЭ

Дугаар . . . . . .

### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1.Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэгт заасны дагуу нийгмийн даатгалд сайн дураар даатгахаар нэг талаас................................ аймаг (хот)-ийн ................................ дүүрэг (сум)-ийн нийгмийн даатгалын газар (тасаг)-ийг төлөөлж, байцаагч ................................ эцэг (эх)-ийн нэр ................................өөрийн нэр (цаашид "нийгмийн даатгалын байгууллага (байцаагч)" гэх), нөгөө талаас иргэн .........................эцэг (эх)-ийн нэр ......................... өөрийн нэр (цаашид "даатгуулагч" гэх) нар (цаашид "талууд" гэх) харилцан тохиролцож энэхүү гэрээг байгуулав.

1.2.Даатгуулагч эхийн иргэний бүртгэлийн дугаар:

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | |

1.3.Гурав хүртэлх насны хүүхдийн регистрийн дугаар

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | |

1.4.Даатгуулагч эхийн төрөл: (тохирох хэсгийн ард (√) тэмдэглэнэ

| | | |
|---|---|---|
| 1. | Жирэмсний болон амаржсаны тэтгэмж авах эрх үүссэн, 3 хүртэлх настай хүүхдээ асарч буй эх | |
| 2. | Жирэмсний болон амаржсаны тэтгэмж авах эрх үүсээгүй, 3 хүртэлх настай хүүхдээ асарч буй эх | |

### Нийгмийн даатгалын шимтгэл ногдуулж төлөх орлогын хэмжээ, хувь, хугацаа

1.5.Гэрээний хүчинтэй байх хугацаа: . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . .
/эхлэх / (он, сар,өдөр) /дуусах/ (он, сар,өдөр)

*Тайлбар: Гэрээний хугацаа нь гэрээ байгуулсан сараас эхлэн хүүхдийг 3 нас хүртэл хугацаанд хүчинтэй байна.*

1.6.Нийгмийн даатгалын шимтгэл ногдуулж төлөх сарын цалин хөлс, орлого: . . . . . .... . төгрөг.

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ ТЭАГУУГ
ХУУЛБАР ҮНЭН
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ГАЗРЫН ДАРГА
Гарын үсэг:
20 21 он 12 сар 27 өдөр

Түүнд ногдуулж сар бүр өөрөө хариуцан төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн дүн: ..................... төгрөг

Тэтгэмжийн даатгалын сангаас (улсын төсвөөс) хариуцан сард төлөх дүн .............. төгрөг байна.

1.6.1.Даатгуулагчийн энэхүү гэрээний 1.6-д заасан өөрөө мэдүүлсэн шимтгэл төлөх, тэтгэвэр, тэтгэмж тогтооход баримтлах сарын цалин хөлсний доод хэмжээ нь тухайн мөрдөж байгаа сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс багагүй, дээд хэмжээ нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 7 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцүү байна. Гэрээний хугацаанд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ эрх бүхий байгууллагын шийдвэрээр шинэчлэн тогтоогдсон тохиолдолд уг шийдвэрийг хэрэгжих хугацаанаас нь эхлэн дагаж, мөрдөнө.

1.6.2.Гэрээний 1.6-д заасан орлого нь шинэчлэн баталсан хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс бага тохиолдолд уг шийдвэрийг дагаж мөрдөх хугацаанаас эхлэн өөрчлөгдсөн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр, дээд хэмжээ нь багассан тохиолдолд шинэчлэгдсэн дээд хэмжээгээр өөрчлөгдсөнд тооцно.

1.6.3.Энэ гэрээний 1.6-д заасан нийгмийн даатгалын шимтгэл ногдуулж, төлж буй сарын цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын хэмжээ нь энэхүү гэрээний 1.6.2-т зааснаас бусад тохиолдолд 12 сарын дотор өөрчлөгдөхгүй.

1.6.4.Даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын хэмжээг гэрээ байгуулснаас хойш 12 сар тутамд нэг удаа өөрчилж болно.

1.7.Энэ гэрээний 1.6-д заасан сарын цалин хөлснөөс тэтгэврийн даатгалын санд 11.5 хувь, тэтгэмжийн даатгалын санд 1.0 хувь, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын санд 1.0 хувиар тооцож нийт 13.5 хувийн нийгмийн даатгалын шимтгэл төлнө.

